

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЗОРИУЛАЛТТАЙ ТҮЛШ, ТӨХӨӨРӨМЖ АШИГЛАЛТЫН 20 ... ОНЫ ӨРХИЙН СУДАЛГАА

1.ХАЯГИЙН ХЭСЭГ

	код	
Дүүргийн нэр:		
Хорооны дугаар:		

1. Хорооны Засаг дарга судалгааг дүүргийн ЗДТГ-т жил бүрийн 2-р сарын 15-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Дүүргийн ЗДТГ нь судалгааг хороо бүрээр нэгтгэж, цахим хэлбэрээр 2-р сарын 25-ны дотор Нийслэлийн Агаарын чанарын албанд хүргүүлнэ.
3. НАЧА нь судалгааг хянаж, баталгаажуулан хороо, дүүргийн дүнгээр нэгтгэн УБ хотын ЗАА-нд 3-р сарын 10-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.
4. УБ хотын ЗАА нь ҮСХ-нд жил бүрийн 3-р сарын 15-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

Агаарын бохирдлыг бууруулах бүтээгдэхүүний нэр	МД	Өрхийн тоо	Бүтээгдэхүүний тоо
А	Б	1	2
Эрчим хүчний хэмжнэлттэй зуух хэрэглэдэг, бүгд мөр 1= мөр (2:10)	1		
үүнээс	Зуух 1 (Хас)	2	
	Зуух 2 (Дөл)	3	
	Зуух 3 (Өлзий)	4	
	Зуух 4 (Голомт)	5	
	Зуух 5 (Талст)	6	
	Зуух 6 (Бекас)	7	
	Зуух 7 (Илч)	8	
	Усан халаалтын зуух	9	
Бусад	10		
Боловсруулсан түлш хэрэглэдэг, бүгд мөр 11=мөр (12:15)	11		
үүнээс	Түлш 1 (Үртсэн шахмал)	12	
	Түлш 2 (Нүүрсэн шахмал түлш)	13	
	Түлш 3 (Хагас коксон шахмал түлш)	14	
	Бусад	15	
Яндангийн шүүлтүүр хэрэглэдэг, бүгд	16		
Дулаан баригч хэрэглэдэг, бүгд	17		
Бусад төрлийн бүтээгдэхүүн ашигладаг, бүгд мөр 18= мөр (19:22)	18		
үүнээс	Цахилгаан	19	
	Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	20	
	Хийн төхөөрөмж	21	
	Бусад	22	

Бүртгэсэн: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: _____

Гарын үсэг: _____ \

Өрхийн агаарын бохирдлыг бууруулах зориулалттай бүтээгдэхүүн ашиглалтын 20... оны судалгааны маягт (ЭАБ-4а) - ыг нөхөх заавар

Хорооны Засаг дарга нь агаарын бохирдлыг бууруулах зориулалттай бүтээгдэхүүн ашиглалтын судалгааг маягтын дагуу нэгтгэн гаргана.

1. ХАЯГИЙН ХЭСЭГ

Байршил: Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд нөхнө. Хорооны дугаарыг "Хүн ам"-ын мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон www.ubstat.mn цахим хуудсаас авч нөхнө.

Судалгаанд зөвхөн Нийслэлийн Агаарын чанарын албанаас баталгаажсан зуухыг хамруулна. Харин энгийн эсвэл НАЧА-аас баталгаажилт хийгээгүй зуухыг хамруулахгүй.

2. МЭДЭЭНИЙ ХЭСЭГ

1, 2 дугаар баганад: 1 дүгээр баганад агаарын бохирдлыг бууруулах бүтээгдэхүүнийг ашиглаж буй өрхийн тоо, 2 дугаар баганад агаарын бохирдлыг бууруулах зорилгоор ашиглаж буй бүтээгдэхүүний тоог давхардуулахгүйгээр нөхнө. Эрчим хүчний хэмнэлттэй зуух гэж агаарын бохирдлыг бууруулах зорилготой бүрэн шаталттай түлшний хэмнэлттэй зуухыг хэлнэ. Эрчим хүчний хэмнэлттэй зуух нь ердийн (Хас, Дөл, Өлзий, Голомт, Талст, Бекас, бусад) болон усан халаалтын (Илч, бусад) гэсэн 2 үндсэн төрөл байна. 1 дүгээр мөрийн дүн нь 2-10 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

2-10 дугаар мөрөнд: Хас, Дөл, Өлзий, Голомт, Талст, Бекас, Илч болон бусад төрлийн зуух ашиглаж байгаа өрхийн тоо болон ашиглаж буй бүтээгдэхүүний тоог давхардуулахгүйгээр нөхнө.

11 дүгээр мөрөнд: Боловсруулсан түлш хэрэглэдэг өрх, бүтээгдэхүүний тоог давхардуулахгүйгээр нөхнө. Боловсруулсан түлш гэж шаталт бүрэн явагддаг утаа бага гаргах технологитой химийн үйлдвэрийн аргаар хийсэн түлшийг хэлнэ. Түлшний хувьд хатуу түлшний сайжруулсан үндсэн 3 төрлийг оруулна. Энгийн хэрэглээний түлш буюу мод, аргал, түүхий нүүрс хэрэглэдэг өрхийг боловсруулсан түлш хэрэглэдэг өрхийн тоонд оруулахгүй. 11 дүгээр мөрийн дүн нь 12-15 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

12-15 дугаар мөрөнд: Үртсэн түлш, нүүрсэн шахмал түлш, хагас коксжсон түлш хэрэглэдэг өрх, бүтээгдэхүүний тоог нөхнө. Үртсэн шахмал түлш гэж үртэс, нүүрсний хог хаягдал, шатамхай коксийн нэгдлүүдээс гаргаж авсан түлшийг хэлнэ. Нүүрсэн шахмал түлш гэж нүүрсний хог хаягдлыг коксжуулсан нүүрсний элементтэй хольж боловсруулсан түлшийг хэлнэ. Хагас коксжсон шахмал түлш гэж коксжуулсан нүүрсний хог хаягдлыг барьцамтгай химийн нэгдлүүдтэй боловсруулж гаргасан түлшийг хэлнэ.

16 дугаар мөрөнд: Яндангийн шүүлтүүр хэрэглэдэг өрх, бүтээгдэхүүний тоог нөхнө. Яндангийн бүх төрлийн шүүлтүүр хэрэглэдэг өрхийг энд хамруулна.

17 дугаар мөрөнд: Дулаан баригч хэрэглэдэг өрхийн тоог нөхнө. Дулаан баригч нь монгол гэрийн энгийн зууханд зориулагдсан төхөөрөмж юм.

18 дугаар мөрөнд: Агаарын бохирдлыг бууруулахад ашигладаг бусад төрлийн бүтээгдэхүүнийг ашигладаг өрх, бүтээгдэхүүний тоог нөхнө. 18 дугаар мөрийн дүн нь 19-22 дугаар мөрийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

19 дүгээр мөрөнд: Цахилгаан ашиглан халаалтын хэрэгцээгээ шийдсэн өрх, бүтээгдэхүүний тоог нөхнө. Цахилгаан эх үүсвэрт бүх төрлийн цахилгаан халаагуур, усан халаалтын систем, цахилгаан хий, цахилгаан хатуу түлш гэх мэт шаардлагатай хэрэгцээний дийлэнх хэсгийг цахилгаан эрчим хүчнээс хангаж байгаа төхөөрөмжийг оруулж тооцно.

20 дугаар мөрөнд: Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж ашиглан халаалтын хэрэгцээгээ хангаж байгаа өрх, бүтээгдэхүүний тоог нөхнө. Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжид халаалт, дулааны хэрэгцээний 30%-иас багагүй хэсгийг хангах газрын гүний дулаан, нарны коллектор зэргийг хамруулна.

21 дүгээр мөрөнд: Хийн төхөөрөмж ашиглан дулааны хэрэгцээгээ хангаж байгаа өрх, бүтээгдэхүүний тоог нөхнө. Хийн төхөөрөмжинд халаалт, дулааны хэрэгцээний 50%-иас доошгүй хэсгийг хангах бүх төрлийн хийн түлшийг хамруулна. Хийн түлш гэдэгт нефтийн шингэрүүлсэн хий, байгалийн хий, нүүрс, хог хаягдал, биомассаас гаргаж авсан бүх төрлийн нүүрс-устөрөгч бүхий хийн байдалтай, шатамхай нэгдлүүдийг оруулна.

22 дугаар мөрөнд: Дээрх гурван төрлөөс бусад төрлийн бүтээгдэхүүнийг хэрэглэдэг өрх, бүтээгдэхүүний тоог нөхнө